26	Өнгөговь аймагын "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам	2019-2026	Барилгын ажлын явц	%	82	100	-	-	-	Зам, тээврийн яам	
27	Өнгөговь аймагын Ханхонгор сумын Тавантолгой, Баруундаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл-Уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	30	75	100	-	Зам, тээврийн яам	
28	Дорнод аймагын Чойбалсан хотын Хаавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам	2022-2028	Барилгын ажлын явц	%	22	50	75	100	-	Зам, тээврийн яам	
29	Өндөрхаан-Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 248.3 км хатуу хучилттай авто зам	2022-2030	Барилгын ажлын явц	%	30	40	55	70	85	100	Зам, тээврийн яам
30	Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам	2025-2030	Барилгын ажлын явц	%	5	10	30	55	80	100	Зам, тээврийн яам
31	Баруун-Урт-Бичигт чиглэлийн 152 км хатуу хучилттай авто зам	2025-2028	Барилгын ажлын явц	%	10	17	60	100	-	Зам, тээврийн яам	
32	Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх төлбөртэй худалдааг дэмжих төсөл/Хавирга, Цагааннуур, Булган боомт	2023-2030	Барилгын ажлын явц	%	2	10	30	55	80	100	Сангийн яам
33	Хилийн Цагаандэл-Уул боомтын барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээ, авто зам талбайн барилга	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	30	75	100	-	Сангийн яам	
ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ											
34	Өнгөговь аймаг дахь Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц	2026-2030	Барилгын ажлын явц	%	-	20	40	60	80	100	Эрчим хүчний яам
35	Баянгийн 660 МВт-ын дулааны цахилгаан станц	2024-2028	Барилгын ажлын явц	%	40	60	80	100	-	Эрчим хүчний яам	
36	Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	30	75	100	-	Эрчим хүчний яам	
37	Эрдэнэбулрагийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц	2025-2030	Барилгын ажлын явц	%	5	20	55	70	85	100	Эрчим хүчний яам
38	Дулааны тавуудаар цахилгаан станц (ДЦС-5)	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	30	75	100	-	Эрчим хүчний яам	
39	Баяннуур-Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 188 км цахилгаан дамжуулах агаарын шугам, "Чойр" дэд станцын өргөтгөл	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	5	55	100	-	Эрчим хүчний яам	



40	Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 220.04 км цахилгаан дамжуулах агаарын шугам, Сайншанд дэд станцтай өргөтгөл	2025-2028	Барилгын ажлын явц	%	-	15	55	100	-	-	Эрчим хүчний яам
41	Эрдэнэбүрэн-Мяндаг чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц /Хөд, Эрдэнэбүрэн, Мяндаг сум/	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	15	55	100	-	-	Эрчим хүчний яам
42	Мандагтовы-Арайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 287 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, "Өвөрхангай" дэд станц	2026-2028	Барилгын ажлын явц	%	-	10	60	100	-	-	Эрчим хүчний яам
43	10 аймгийн төвд дулааны станц, Дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв	2020-2028	Барилгын ажлын явц	%	65	70	85	100	-	-	Эрчим хүчний яам
44	Налайх дүүргийн дулааны 2/16 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр /эхний ээлж 79 МВт/	2025-2027	Барилгын ажлын явц	%	25	60	100	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
45	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг дээшлүүлэх төсөл	2020-2026	Барилгын ажлын явц	%	90	100	-	-	-	-	Эрчим хүчний яам
46	Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын дулааны цахилгаан станц	2024-2026	Барилгын ажлын явц	%	75	100	-	-	-	-	Эрчим хүчний яам
47	Шивээ-Овоогийн 660 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц	2027-2030	Барилгын ажлын явц	%	-	-	35	70	90	100	Эрчим хүчний яам
48	Дамбадаржаа дэд төвд дулааны станц	2025-2027	Барилгын ажлын явц	%	40	70	100	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
49	Их чадлын өөрийгөө цэнэглэх батарей хуримтлуурын төсөл	2026-2030	Барилгын ажлын явц	%	-	10	20	50	80	100	Эрчим хүчний яам
50	Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн төсөл	2026-2030	Ажлын явц	%	-	-	10	50	90	100	Эрчим хүчний яам
БҮСИЙН ХӨГЖИЛ											
51	Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2025-2034	Барилгын ажлын явц	%	-	5	15	25	35	45	Эдийн засаг, хөгжлийн яам
52	Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл	2023-2028	Барилгын ажлын явц	%	1	15	55	100	-	-	Зам, тээврийн яам
53	Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гэрц барих төсөл	2022-2026	Барилгын ажлын явц	%	50	100	-	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
54	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл	2020-2026	Барилгын ажлын явц	%	40	100	-	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
55	Сэлбэ дэд төв орон сууцнуулах төсөл	2026-2029	Барилгын ажлын явц	%	-	25	50	75	100	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
56	Баянхоншуу дэд төв орон сууцнуулах төсөл	2025-2030	Барилгын ажлын явц	%	25	35	50	70	90	100	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
57	Туулын хурдны зам	2025-2028	Барилгын ажлын явц	%	20	60	80	100	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
58	Шинэ тойрог зам /1 дүгээр тойрог/	2026-2030	Барилгын ажлын явц	%	-	5	10	20	60	100	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
59	Эмээлт энэ аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц	2025-2030	Барилгын ажлын явц	%	5	25	45	65	85	100	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
60	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл	2019-2026	Барилгын ажлын явц	%	47	100	-	-	-	-	Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яам



61	Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих төсөл	2025-2029	Барилгын ажлын явц	%	70	75	85	95	100	-	Хот байгуулалт, барилга, орон сургуулиудын яам
62	Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үүрэгдэд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх төсөл	2026-2027	Барилгын ажлын явц	%	-	50	100	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
63	Улиастай-Алтай чиглэлийн 100 км хатуу хүчилтэй авто зам	2026-2029	Барилгын ажлын явц	%	-	25	50	75	100	-	Зам, тээврийн яам
64	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хүчилтэй авто зам	2026-2029	Барилгын ажлын явц	%	-	25	50	75	100	-	Зам, тээврийн яам
65	Чойр-Мандаглов-Арайзээр чиглэлийн 487.73 км хатуу хүчилтэй авто зам	2025-2032	Барилгын ажлын явц	%	7	-	25	40	55	70	Зам, тээврийн яам
66	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл	2025-2030	Барилгын ажлын явц	%	4	10	35	60	85	100	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
67	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл/хоёр үе шаттай/	2026-2029	Барилгын ажлын явц	%	-	25	50	75	100	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
68	"Шинэ Хөд" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төсөл	2022-2028	Барилгын ажлын явц	%	70	80	90	100	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
69	Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл, технологийн цогцолборын дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төсөл	2024-2028	Барилгын ажлын явц	%	30	40	60	100	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
70	"Зак зээл ба болчээрийн удирдлага төсөл"-ийн II үе шат	2026-2029	Барилгын ажлын явц	%	-	-	35	70	100	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
71	Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн 179.7 км хатуу хүчилтэй авто зам	2024-2030	Барилгын ажлын явц	%	15	30	45	60	80	100	Зам, тээврийн яам
72	Жаргалхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км хатуу хүчилтэй авто зам	2024-2028	Барилгын ажлын явц	%	35	70	85	100	-	-	Зам, тээврийн яам
73	Жаргалхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн 152.5 км хатуу хүчилтэй авто зам	2024-2030	Барилгын ажлын явц	%	5	15	35	55	80	100	Зам, тээврийн яам
74	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 59.2 км хатуу хүчилтэй авто замын дуусгал	2025-2028	Барилгын ажлын явц	%	20	40	70	100	-	-	Зам, тээврийн яам
75	Орхонтун-Цээл чиглэлийн 62.56 км хатуу хүчилтэй авто зам	2025-2028	Барилгын ажлын явц	%	25	45	85	100	-	-	Зам, тээврийн яам
76	Өгнийнур-Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн 28.5 км хатуу хүчилтэй авто зам	2025-2027	Барилгын ажлын явц	%	40	70	100	-	-	-	Зам, тээврийн яам
77	Солонготын давааны 12.08 км хатуу хүчилтэй авто зам	2025-2027	Барилгын ажлын явц	%	40	90	100	-	-	-	Зам, тээврийн яам
78	Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.18 км хатуу хүчилтэй авто зам	2024-2027	Барилгын ажлын явц	%	25	85	100	-	-	-	Зам, тээврийн яам
79	Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хүчилтэй авто зам	2022-2028	Барилгын ажлын явц	%	20	60	80	100	-	-	Зам, тээврийн яам
80	Улаанбаатар-Арайзээр чиглэлийн авто замаас Хүжирт сум хүртэлх 43.3 км хатуу хүчилтэй авто зам	2024-2027	Барилгын ажлын явц	%	30	85	100	-	-	-	Зам, тээврийн яам
81	Өлгий-Сарсай-Улаанхус-Цанзал сум чиглэлийн 66 км хатуу хүчилтэй авто замын дуусгал	2025-2030	Барилгын ажлын явц	%	15	30	50	65	85	100	Зам, тээврийн яам

82	Хөд-Дөргөн сум чиглэлийн 40.7 км хатуу хучилттай авто зам	2024-2027	Барилгын ажлын явц	%	40	90	100	-	-	-	Зам, тээврийн яам
83	Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох 32.4 км хатуу хучилттай авто зам	2024-2027	Барилгын ажлын явц	%	40	90	100	-	-	-	Зам, тээврийн яам
84	Увс нуур-Улаангом чиглэлийн 26.39 км хатуу хучилттай авто замын эхний үе шат	2024-2027	Барилгын ажлын явц	%	15	80	100	-	-	-	Зам, тээврийн яам
НОГООН ХӨГЖИЛ											
85	Ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх	2025-2028	Барилгын ажлын явц	%	-	30	65	100	-	-	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЗАСАГЛАЛ											
86	Монгол Улсад гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл	2026-2031	Барилгын ажлын явц	%	-	2	20	40	60	80	Шадар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжилсний байдлын асуудал эрхэлсэн/
87	Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх төсөл	2026-2031	Барилгын ажлын явц	%	-	-	20	40	60	80	Шадар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжилсний байдлын асуудал эрхэлсэн/
88	Батлан хамгаалах салбарын чадварыг бэхжүүлэх жетөлбөр-1	2025-2030	Барилгын ажлын явц	%	2	13	25	40	70	100	Батлан хамгаалах яам

---000---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд доор дурдсан хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх:

а/Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах, төлөвлөх, батлах, гүйцэтгэлийг тайлагнах, тайланг хэлэлцэх журам, цаглавартай холбоотой хууль хоорондын зөрчлийг арилгахад чиглэгдсэн хуулийн төсөл;

б/улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сахилга хариуцлага, хяналтыг сайжруулах, ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх зорилгоор улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах аргачлал, уг хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх зарчим, шалгуурыг тогтоосон хуулийн төсөл.

2/төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, хөдөлмөрийн үнэлэмж, цалин хөлсний талаар баримталж байгаа бодлого, тогтолцоонд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох санал боловсруулан 2026 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

3/Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтад “Тооцох” гэж тусгасан суурь түвшнийг хэмжих аргачлалыг тодорхой болгон тооцоолж, бусад шалгуур



үзүүлэлтийг тухайн үед байгаа түвшний хамт тоон үзүүлэлтээр гарган 2026 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

4/“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлэх;

5/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд санхүүжилтийн эх үүсвэр нь хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэгдсэн, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн төслийг “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тухай бүр шийдвэрлүүлэх;

6/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн” болон “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-д заасан зорилтыг хангахуйц, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зарчим, шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг улсын эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, 2027, 2028, 2029, 2030 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байх;

7/Монгол Улсын нэгдсэн төсвийн жил бүрийн гүйцэтгэлд “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-д заасан зорилтот түвшинд хүрсэн эсэх, тухайн онд хүрсэн түвшин, төсвийн гүйцэтгэлээр хүрсэн түвшнийг тус тус тусгаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх;

8/дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан хүрээнд боловсруулж, 2026 онд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/, Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

استقامت في العمل والدراسة

المستقيم

366 *Journal of Management Inquiry*

٥٥٦٢١٧٠ و ٥٦٦٢١٧٠ - ص ١٧٦

يُصَنَّفُ الْمَعْمُورُ فِي ٥٠٥-٥٠٦ مِثْلَ الْفَتْحِ الْكَلْبِيِّ

يُصَنَّفُ بِمَصْرٍ مَرَكَبًا رَاسِيٍّ مَرَّ حَضَرَ رَاسِيٍّ . يَصْنَعُ بِمَصْرٍ مَرَّ حَضَرَ رَاسِيٍّ . يَصْنَعُ بِمَصْرٍ مَرَّ حَضَرَ رَاسِيٍّ .

۶. حضرت مصمم نے ۱۹۵۵ء-۱۹۵۶ء کے دور میں محکمہ تعلیم کے لیے ایک خصوصی اسکول بنوا دیا۔ یہ اسکول "مدرسہ اسلامیہ" کے نام سے مشہور ہوا۔

[illegible][illegible][illegible][illegible]

ز.ح.م.س



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолд тусгасан ногоон эдийн засгийг дэмжих, ногоон төслийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх замаар эрчим хүчний болон газрын тосны импортын хараат байдлыг бууруулах, үндэсний эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний алдагдлыг бууруулах, ногоон технологид суурилсан тогтвортой аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх болон байгаль орчинд ээлтэй зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, олон улсын стандартад нийцсэн ногоон барилга, хот байгуулалтын технологи, шийдлийг нэвтрүүлэхэд чиглэсэн төслийн санал, санаачилгыг дэмжих;

2/эрхийн болон орон нутгийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, айл өрхүүдэд нарны панель, батарей, халаагуур хосолсон системийг үе шаттайгаар суурилуулах, хэт урт шугамын цахилгаанаар хангагддаг аймаг, сум, суурин газрын сэргээгдэх эрчим хүчний бие даасан эх үүсвэр, эрчим хүч хуримтлуур бүхий системээр хангах замаар төвлөрсөн шугам сүлжээний ачаалал, алдагдлыг бууруулах, хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг сайжруулах;

3/цахилгаан тээврийн хэрэгслийн нийтийн хурдан цэнэглэх дэд бүтцийг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурласан сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр бүхий олон улсын туршлагад нийцсэн цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд бүтцийн багц төслийг нэвтрүүлэх.

2.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд

заасан удирдамжийн хүрээнд гадаад улстай байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар карбон кредитийг хөгжүүлж, энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээтэй холбоотой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үр өгөөжтэй байдлаар ашиглах, Монгол Улсад орох хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэхийг чиглэл болгон ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай.

3.Цахилгаан эрчим хүчний импортыг бууруулах, төвлөрсөн эрчим хүчний системээс алслагдсан хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох, ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилтийн хөрөнгө оруулалтын боломжийг өргөтгөх, тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын 1 дэх заалтыг богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/ногоон төслийн бэлэн байдлыг хангуулах хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах арга хэмжээг зохион байгуулах;

2/тархмал эх үүсвэрийг түгээх сүлжээнд холбох, илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан дүрэм, журмыг иргэн, хувийн хэвшилд ойлгомжтой, хэрэглэгчид ээлтэй, шийдвэр гаргалт, үйл ажиллагааг ил тод, шуурхай болгож, өөрчлөх;

3/20 кВт хүртэлх хүчин чадалтай нарны панель, батареин системийг техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг стандартыг хангуулан түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон орлогыг нийлүүлэгчид тухай бүр авах боломжийг бүрдүүлэх;

4/өөрийн хэрэглээг хангаж, эрчим хүчээ хэмнэх зорилготой, түгээх сүлжээнд цахилгаан нийлүүлэхгүй тархмал эх үүсвэрийг техникийн нөхцөл шаардахгүйгээр 10 кВт хүртэлх хүчдэлийн түгээх сүлжээнд холбох боломжийг бүрдүүлэх;



5/эрчим хүчний хэмнэлттэй сууц, стандартад нийцүүлэн сууцаа дулаалсан айл өрхөд нарны панель, батарей, халаагуур хосолсон системийг үе шаттайгаар нэвтрүүлж, халаалтын асуудлыг шийдвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах, цэвэр, эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх;

6/төвлөрсөн эрчим хүчний системээс алслагдсан, хэт урт шугамын цахилгаанаар хангагддаг, эрчим хүчний алдагдал өндөртэй бүс нутагт тархмал эх үүсвэр, эрчим хүч хуримтлуурын нэгдсэн шийдлийг үе шаттайгаар нэвтрүүлэх;

7/тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд төслийн нэгжийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, урт хугацааны, хөнгөлөлттэй санхүүжилт татах, нийлүүлэлтийн сүлжээг оновчтой зохион байгуулах арга хэмжээг авах;

8/тархмал эх үүсвэр бүхий халаалтын системийг нутагшуулах зорилгоор олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, зураг төсөл, угсралт, суурилуулалт, туршилт тохируулга, засвар үйлчилгээ, ашиглалтын инженер, техникийн ажилтан, гүйцэтгэгчийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр мэргэжлийн холбоо, сургалтын байгууллагатай хамтран чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хүний нөөцийг орон нутгаас бэлтгэж, төслийн бүтээн байгуулалт, туршилт тохируулга, засвар үйлчилгээ, ашиглалтын ажилд орон нутгийн ажиллах хүчний оролцоог дэмжих;

9/тархмал эх үүсвэрээс эрчим хүч худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг түншлэгч, төсөл хэрэгжүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тусгай нөхцөлөөр байгуулж, сонгогдсон байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох, эсхүл улсын тусгай хэрэгцээнд авч, төслийг саадгүй хэрэгжүүлэх боломжоор хангах;

10/олон улсын, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто зам, аялал жуулчлал, логистик, худалдааны коридор дагуух стратегийн байршилд сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр бүхий цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх станц байгуулах, үйлдвэрлэсэн ногоон эрчим хүчийг дотоодын хэрэглээнд үр ашигтайгаар шингээх, нийтийн хурдан цэнэглэх дэд бүтцийг хот болон хот хоорондын авто тээврийн бодлоготой уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

11/бүрэн цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл болон туулах зай уртасгагчтай цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгслийг

байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслийн ангилалд оруулж, замын хөдөлгөөний дугаарын хязгаарлалтад хамруулахгүй байх зохицуулалтыг нэвтрүүлж хэрэгжүүлэх;

12/агаарын бохирдол, эрчим хүчний алдагдлыг бууруулах зорилтын хүрээнд гэр, хувийн сууц, барилга байгууламжийн дулаан төсөл болон эрчим хүчний, ногоон барилга байгууламжийг барих, цэнэглэх станцын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг “ногоон төсөл”-ийн ангилалд хамруулж, зөвшөөрөл олголтыг хялбаршуулах, холбогдох зөвшөөрлийг, төсөл хэрэгжүүлэгчид Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээг тус тус олгох, ногоон төслийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

13/хот байгуулалт, дахин төлөвлөлт, эрчим хүчний сүлжээний өргөтгөл, орон сууцны бодлогыг агаарын бохирдлыг бууруулах бодлоготой уялдуулан дулаалгын төслийг хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид дулаалгын ажлыг үлгэрчилсэн байдлаар хэрэгжүүлж, зах зээлийн тогтвортой эрэлтийг бий болгох;

14/дулаалгын төслийн үр дүнд бий болох эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлын бууралтад үндэслэн карбон кредит тооцох, бүртгэх, арилжаалах боломжийг бүрдүүлэх, “хэмжилт, тайлагнал баталгаажуулалт” /MRV/-ын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн нэвтрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

15/дулаалгын төслийн хэрэгжилт, санхүүжилтийн үр ашиг, бодит үр нөлөөнд тогтмол мониторинг хийх, агаарын бохирдлыг хэмжих үндэсний сүлжээг бий болгож үнэлгээ хийх, хэрэгжилтийн үр дүнд тулгуурлан бодлогын дэмжлэгийн механизмыг үе шаттайгаар сайжруулах;

16/агаарын бохирдлын төлбөрөөс төсөвт төвлөрөх орлогыг агаарын бохирдлыг бууруулах дулаалгын төслийг хэрэгжүүлэх эх үүсвэрт төвлөрүүлж, олон улсаас ногоон санхүүжилт татах бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

6.Энэ тогтоолын 4 дэх заалтад заасан арга хэмжээний явц, биелэлтийн талаар Улсын Их Хуралд 2026 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай.



7.Эрчим хүчний бие даасан байдлыг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн уялдаа холбоог хангуулж, эрчимжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

8.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

استقامت في العمل والدراسة

الحسين بن محمد

۹۹۹

٥٠٤٢ لمر و ٦٨ هجرت قمرية [المجلد ١ - و المجلد

حسب من نكحت هو طابع بحدود خمس

[illegible][illegible][illegible][illegible][illegible]

[illegible][illegible][illegible][illegible]

١٠٠
١٠١
١٠٢
١٠٣
١٠٤
١٠٥
١٠٦
١٠٧
١٠٨
١٠٩
١١٠
١١١
١١٢
١١٣
١١٤
١١٥
١١٦
١١٧
١١٨
١١٩
١٢٠
١٢١
١٢٢
١٢٣
١٢٤
١٢٥
١٢٦
١٢٧
١٢٨
١٢٩
١٣٠
١٣١
١٣٢
١٣٣
١٣٤
١٣٥
١٣٦
١٣٧
١٣٨
١٣٩
١٤٠
١٤١
١٤٢
١٤٣
١٤٤
١٤٥
١٤٦
١٤٧
١٤٨
١٤٩
١٥٠
١٥١
١٥٢
١٥٣
١٥٤
١٥٥
١٥٦
١٥٧
١٥٨
١٥٩
١٦٠
١٦١
١٦٢
١٦٣
١٦٤
١٦٥
١٦٦
١٦٧
١٦٨
١٦٩
١٧٠
١٧١
١٧٢
١٧٣
١٧٤
١٧٥
١٧٦
١٧٧
١٧٨
١٧٩
١٨٠
١٨١
١٨٢
١٨٣
١٨٤
١٨٥
١٨٦
١٨٧
١٨٨
١٨٩
١٩٠
١٩١
١٩٢
١٩٣
١٩٤
١٩٥
١٩٦
١٩٧
١٩٨
١٩٩
٢٠٠
٢٠١
٢٠٢
٢٠٣
٢٠٤
٢٠٥
٢٠٦
٢٠٧
٢٠٨
٢٠٩
٢١٠
٢١١
٢١٢
٢١٣
٢١٤
٢١٥
٢١٦
٢١٧
٢١٨
٢١٩
٢٢٠
٢٢١
٢٢٢
٢٢٣
٢٢٤
٢٢٥
٢٢٦
٢٢٧
٢٢٨
٢٢٩
٢٣٠
٢٣١
٢٣٢
٢٣٣
٢٣٤
٢٣٥
٢٣٦
٢٣٧
٢٣٨
٢٣٩
٢٤٠
٢٤١
٢٤٢
٢٤٣
٢٤٤
٢٤٥
٢٤٦
٢٤٧
٢٤٨
٢٤٩
٢٥٠
٢٥١
٢٥٢
٢٥٣
٢٥٤
٢٥٥
٢٥٦
٢٥٧
٢٥٨
٢٥٩
٢٦٠
٢٦١
٢٦٢
٢٦٣
٢٦٤
٢٦٥
٢٦٦
٢٦٧
٢٦٨
٢٦٩
٢٧٠
٢٧١
٢٧٢
٢٧٣
٢٧٤
٢٧٥
٢٧٦
٢٧٧
٢٧٨
٢٧٩
٢٨٠
٢٨١
٢٨٢
٢٨٣
٢٨٤
٢٨٥
٢٨٦
٢٨٧
٢٨٨
٢٨٩
٢٩٠
٢٩١
٢٩٢
٢٩٣
٢٩٤
٢٩٥
٢٩٦
٢٩٧
٢٩٨
٢٩٩
٣٠٠
٣٠١
٣٠٢
٣٠٣
٣٠٤
٣٠٥
٣٠٦
٣٠٧
٣٠٨
٣٠٩
٣١٠
٣١١
٣١٢
٣١٣
٣١٤
٣١٥
٣١٦
٣١٧
٣١٨
٣١٩
٣٢٠
٣٢١
٣٢٢
٣٢٣
٣٢٤
٣٢٥
٣٢٦
٣٢٧
٣٢٨
٣٢٩
٣٣٠
٣٣١
٣٣٢
٣٣٣
٣٣٤
٣٣٥
٣٣٦
٣٣٧
٣٣٨
٣٣٩
٣٤٠
٣٤١
٣٤٢
٣٤٣
٣٤٤
٣٤٥
٣٤٦
٣٤٧
٣٤٨
٣٤٩
٣٥٠
٣٥١
٣٥٢
٣٥٣
٣٥٤
٣٥٥
٣٥٦
٣٥٧
٣٥٨
٣٥٩
٣٦٠
٣٦١
٣٦٢
٣٦٣
٣٦٤
٣٦٥
٣٦٦
٣٦٧
٣٦٨
٣٦٩
٣٧٠
٣٧١
٣٧٢
٣٧٣
٣٧٤
٣٧٥
٣٧٦
٣٧٧
٣٧٨
٣٧٩
٣٨٠
٣٨١
٣٨٢
٣٨٣
٣٨٤
٣٨٥
٣٨٦
٣٨٧
٣٨٨
٣٨٩
٣٩٠
٣٩١
٣٩٢
٣٩٣
٣٩٤
٣٩٥
٣٩٦
٣٩٧
٣٩٨
٣٩٩
٤٠٠
٤٠١
٤٠٢
٤٠٣
٤٠٤
٤٠٥
٤٠٦
٤٠٧
٤٠٨
٤٠٩
٤١٠
٤١١
٤١٢
٤١٣
٤١٤
٤١٥
٤١٦
٤١٧
٤١٨
٤١٩
٤٢٠
٤٢١
٤٢٢
٤٢٣
٤٢٤
٤٢٥
٤٢٦
٤٢٧
٤٢٨
٤٢٩
٤٣٠
٤٣١
٤٣٢
٤٣٣
٤٣٤
٤٣٥
٤٣٦
٤٣٧
٤٣٨
٤٣٩
٤٤٠
٤٤١
٤٤٢
٤٤٣
٤٤٤
٤٤٥
٤٤٦
٤٤٧
٤٤٨
٤٤٩
٤٥٠
٤٥١
٤٥٢
٤٥٣
٤٥٤
٤٥٥
٤٥٦
٤٥٧
٤٥٨
٤٥٩
٤٦٠
٤٦١
٤٦٢
٤٦٣
٤٦٤
٤٦٥
٤٦٦
٤٦٧
٤٦٨
٤٦٩
٤٧٠
٤٧١
٤٧٢
٤٧٣
٤٧٤
٤٧٥
٤٧٦
٤٧٧
٤٧٨
٤٧٩
٤٨٠
٤٨١
٤٨٢
٤٨٣
٤٨٤
٤٨٥
٤٨٦
٤٨٧
٤٨٨
٤٨٩
٤٩٠
٤٩١
٤٩٢
٤٩٣
٤٩٤
٤٩٥
٤٩٦
٤٩٧
٤٩٨
٤٩٩
٥٠٠
٥٠١
٥٠٢
٥٠٣
٥٠٤
٥٠٥
٥٠٦
٥٠٧
٥٠٨
٥٠٩
٥١٠
٥١١
٥١٢
٥١٣
٥١٤
٥١٥
٥١٦
٥١٧
٥١٨
٥١٩
٥٢٠
٥٢١
٥٢٢
٥٢٣
٥٢٤
٥٢٥
٥٢٦
٥٢٧
٥٢٨
٥٢٩
٥٣٠
٥٣١
٥٣٢
٥٣٣
٥٣٤
٥٣٥
٥٣٦
٥٣٧
٥٣٨
٥٣٩
٥٤٠
٥٤١
٥٤٢
٥٤٣
٥٤٤
٥٤٥
٥٤٦
٥٤٧
٥٤٨
٥٤٩
٥٥٠
٥٥١
٥٥٢
٥٥٣
٥٥٤
٥٥٥
٥٥٦
٥٥٧
٥٥٨
٥٥٩
٥٦٠
٥٦١
٥٦٢
٥٦٣
٥٦٤
٥٦٥
٥٦٦
٥٦٧
٥٦٨
٥٦٩
٥٧٠
٥٧١
٥٧٢
٥٧٣
٥٧٤
٥٧٥
٥٧٦
٥٧٧
٥٧٨
٥٧٩
٥٨٠
٥٨١
٥٨٢
٥٨٣
٥٨٤
٥٨٥
٥٨٦
٥٨٧
٥٨٨
٥٨٩
٥٩٠
٥٩١
٥٩٢
٥٩٣
٥٩٤
٥٩٥
٥٩٦
٥٩٧
٥٩٨
٥٩٩
٦٠٠
٦٠١
٦٠٢
٦٠٣
٦٠٤
٦٠٥
٦٠٦
٦٠٧
٦٠٨
٦٠٩
٦١٠
٦١١

کتابخانه عمومی
مکتبہ اسلامیہ

زنگنه



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар
хот

**Оюу толгой бүлэг ордын ашиглалтад
Монгол Улсын эрх ашгийг хангуулах,
хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд
хийсэн тусгай шалгалт, нээлттэй
сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын ашиглалттай холбогдуулан дараах арга хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулсан Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтэд нийцүүлэн авч хэрэгжүүлж, үр дүнг Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулж шийдвэрлүүлэх, явцыг улирал тутам Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд нээлттэй танилцуулж, ил тод байдлыг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасуяй:

1/стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хилийн заагт орших “Жавхлант”, “Шивээ толгой” ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл, хуульд нийцсэн байдлыг нягталж, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах, ашиглалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмыг хангаж байхаар төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох санал боловсруулах, ирээдүйд Монголын талын хүртэх үр өгөөжид сөрөг нөлөөлөл, үр дагавар бүхий санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, баяжмалын агууламжийг уурхайн амнаас лабораториор хянан баталгаажуулж, экспортод гаргах;

2/“Эрдэнэс МГЛ” ХХК, “Айвенхоу Оюу Толгой /Би Ви Ай” Лтд, “Оюу Толгой Нидерланд Би Ви”, “Оюу Толгой” ХХК-ийн хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ

/Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон/-ний хэрэгжилтийг харилцан дүгнэх, алдагдсан боломжийн өртгийг тооцоолж, дүгнэлт гаргах, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнд холбогдох бусад гэрээ, эрх зүйн баримт бичгийг нийцүүлэх, хувь нийлүүлэгчийн болон гуравдагч этгээдийн санхүүжилтийн хүүгийг хувь, хэмжээг бодитоор бууруулах;

3/стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын геологи, хайгуулын судалгааг үргэлжлүүлж, үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар тус ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх, ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

4/Монголын талын хүртэх үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан техник, эдийн засгийн үндэслэл /2010 он/-ийн анхны тооцооллын дагуу нэрлэсэн үнээр 53 хувиас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах, уг хувь хэмжээг 3 жил тутам харилцан хянан үзэх зарчмыг нэвтрүүлж, “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагааны жилийн тайланд талуудад ногдох үр өгөөжийн тооцоог тусгайлан тусгаж тайлагнах;

5/“Оюу Толгой” ХХК-ийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк /Монголбанк/ болон арилжааны банкуудаар бүрэн дамжуулдаг болох.

2.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” сэдвийн хүрээнд зохион байгуулсан хяналт шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу шалгаж, шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газар /П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газар /Ж.Болд/-т тус тус зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

[illegible]

معمولاً در این روش، یک عدد تصادفی از یک توزیع مشخص (مثلاً یک توزیع یکنواخت) انتخاب می‌شود و به عنوان یک عدد صحیح در یک محدوده مشخص (مثلاً ۱ تا ۱۰۰) تبدیل می‌شود. این عدد تصادفی به عنوان یک عدد صحیح در یک محدوده مشخص (مثلاً ۱ تا ۱۰۰) تبدیل می‌شود. این عدد تصادفی به عنوان یک عدد صحیح در یک محدوده مشخص (مثلاً ۱ تا ۱۰۰) تبدیل می‌شود.

[illegible][illegible][illegible]

٣. بنر مصطفیٰ م ویکیپیڈیا کی ریشتر متواتر سکتی ہوگی۔

نہ. اعلیٰ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар
хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, 76.2, 76.5 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Навагчамбын Баасанжав, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг, Ренчиндоржийн Онончимэг, Дорждамбын Зүмбэрэлхам нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.

Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар
хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/үнийн өсөлтөөс сэргийлэх, түүний эрсдэлийг бууруулах зорилгоор төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж, төсвийг хэт тэлэх, эрэлтийн гаралтай инфляц үүсэхээс сэргийлэх, дотоодын зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх;

2/уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг биржийн арилжаанаас салгаж, бие даасан байдлаар зохицуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах;

3/хилийн боомт, гаалийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, төр өөрт байгаа мэдээллийг хүн, хуулийн этгээдээс давхардуулан шаардахгүй байх, нэвтрэх хугацааг богиносгох замаар тээврийн зардлыг бууруулах, тээвэр, логиستيкийн саатлаас шалтгаалан импортын барааны үнэ өсөхөөс урьдчилан сэргийлэх;

4/уул уурхайн салбарын өсөлтөөс үүдсэн төсвийн хэт тэлэлтээс хамгаалах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, төсвийн сахилга батыг чангатгах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон нэмэлт орлогыг хуримтлуулах, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, эрчим хүч, дэд бүтэц, боловсрол, технологи зэрэг бусад боломжит салбарт хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийг төрөлжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

5/барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан, эсхүл нарийн технологи шаардсанаас

бусад төрөөс хэрэгжүүлж байгаа томоохон төслүүдийн худалдан авалт, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажилд дотоодын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тохиолдолд дээрх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг шинэчлэх санал боловсруулж, танилцуулах;

6/эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшин өндөр улсуудаас чанартай эмийг бөөнөөр худалдан авч, ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар эмийн үнийг бууруулах, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалтыг хялбаршуулж, үнийн өсөлтөд хяналт тавих;

7/төрөөс үнийг зохицуулж байгаа салбаруудыг инфляцид огцом нөлөө үзүүлэхгүй байхаар тооцож, үе шаттай чөлөөлөх, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан төрийн бүх төрлийн зохицуулалтыг хялбаршуулах;

8/төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх замаар өрхийн орлогыг хамгаалах:

а/төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн байгууллагын бүтэц, чиг үүргийг бүх шатанд нягталж, давхардсан чиг үүрэг, байгууллагыг нэгтгэх, татан буулгах, хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой ажил, үйлчилгээг төр гүйцэтгэхийг хязгаарлах, нийгмийн болон дэд бүтцийн салбарын суурь үйлчилгээг гэрээний үндсэн дээр шаардлагатай нөөцийг ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;

б/бүтээмж, гүйцэтгэлд суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэмж, урамшууллын тогтолцооны загварыг боловсруулж үр чадвар, үр дүнтэй уялдуулсан, цалин урамшууллын системийг нэвтрүүлэх;

в/үр өгөөж бага олон нийтийн арга хэмжээ, сурталчилгаа, гадаад томилолт, автомашин, тавилга худалдан авах зэрэг урсгал зардлыг үе шаттайгаар бодитой бууруулах;

г/хөдөө аж ахуйн болон бусад салбарын татаас, урамшуулал, татварын хөнгөлөлтийн үр дүнг тооцож, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлдэггүй, зорилтот бүлэгт хүрдэггүй дэмжлэгийг өөрчлөх, бүрмөсөн зогсоох;

д/Засгийн газрын тусгай сангуудын давхардлыг арилгаж, зарим санг татан буулгах, сангуудын үйл ажиллагааг ил тод болгож, хяналтыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, танилцуулах;



е/төрийн хяналт шалгалтын тогтолцоог шинэчилж, эрсдэлд суурилсан, давхардал, хүнд сурталгүй, цахимжсан төрийн хяналтыг бэхжүүлж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог төлөвшүүлэх;

ё/бизнес эрхлэхэд хүндрэл, чирэгдэл учруулж байгаа эрх зүйн баримт бичгийг судалж, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох арга хэмжээ авах;

ж/хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжихэд чиглэсэн бизнесийн шударга өрсөлдөөн, эрх тэгш байдлыг хангах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах;

з/хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох үүднээс ядуурал, ажилгүйдлийг бууруулах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын шинэчлэлийг орлогын дахин хуваарилалттай хамтад нь хийх асуудлыг цогцоор нь судалж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах;

и/хөрөнгийн биржийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тус биржийн төрийн өмчийн хувьцааны эзлэх хувийг бууруулах, нээлттэй хэлбэрээр хувьчлах, мэргэжлийн байгууллага, хөрөнгө оруулагчтай урт хугацаанд гэрээ байгуулж хамтарч ажиллах хувилбаруудыг судалж, танилцуулах.

2.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /С.Наранцогт/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-нд даалгасгай:

1/өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах, иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

2/гадаадын банкуудын салбарыг холбогдох хуулийн дагуу дотоодын зах зээлд нэвтрүүлж, өрсөлдөөнийг дэмжих, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг авах;

3/банкны салбарын реформыг эрчимжүүлж, зээлийн хүүг үе шаттай бууруулах;

4/хөнгөлөлттэй ипотекийн зээлийг агаар, орчны бохирдол, төвлөрлийг бууруулах зорилгоор зорилтот бүлэгт чиглүүлэх, эх

үүсвэрийн бодит өртөг, зах зээлийн зарчимд нийцүүлэн ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

5/гадаад валютын хэрэгцээ, гадаад өр төлбөр, импортын урсгалыг харгалзан гадаад валютын нөөцийг зохистой түвшинд хүргэх, санхүүгийн хэрэгслүүдийг оновчтой ашиглах замаар гадаад валютын урсгалыг тогтворжуулж, нөөцийг нэмэгдүүлэх;

6/Монголбанкны өнгөрсөн хугацааны алдагдлыг нэмэгдүүлсэн суурь шалтгааныг тогтоож, хуримтлагдсан алдагдлыг үе шаттай бууруулах;

7/гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах талаар Монголбанкны хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгох;

8/иргэдийг хэрэглээний зээлийн хэт өсөлт, их хэмжээний өрийн дарамт, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор зээлийн мэдээллийн санд нийлүүлэх арга хэмжээг авах;

9/банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуульд заагаагүй зөвшөөрөл, зөвшөөрөлтэй төстэй зохицуулалт бүхий эрх зүйн баримт бичгийг судалж, хүчингүй болгох;

10/банк, банк бус санхүүгийн байгууллагууд өөрийн харилцан хамаарал бүхий этгээдээр дамжуулан лизинг, мөнгөн зээлийн үйл ажиллагааг хууль бусаар эрхэлж байгааг таслан зогсоох, иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах, холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг авах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж, биелэлтийг заалт бүрээр гаргаж Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монголбанк /С.Наранцогт/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/, Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.УЧРАЛ

زاد: رستم



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 10

Индекс: 200003